

БАТЛАВ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА *А.О.М.* А.ӨТГОНБААТАР

2024 оны 02 дугаар сарын 01-ны өдөр

ЗЮА0035 9033653

2024 оны секц дугуйлангийн хуваарь

№	Спортын төрөл	Дасгалжуулагч	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба, ням
1	Сагсан бөмбөг	О.Буянтогтох 91010766		09.00-11.00	11.00-13.00	11.00-13.00		Тэмцээн уралдаан
				15.00-17.00	13.00-15.00	15.00-17.00	13.00-15.00	
2	Хөлбөмбөг	Б.Баттүвшин 85505168	09.00-11.00		09.00-11.00		09.00-11.00	Тэмцээн уралдаан
			15.00-17.00	13.00-15.00		13.00-15.00		
3	Волейбол	Д.Болор-Эрдэнэ 85657474	11.00-13.00	11.00-13.00		09.00-11.00	11.00-13.00	Тэмцээн уралдаан
			13.00-15.00		15.00-17.00		15.00-17.00	

ХУВААРЬ ГАРГАСАН ДАСГАЛЖУУЛАГЧ

О.БУЯНТОГТОХ

		Цолгүй залуу бөх		=		89044704
Гурав. Оюуны спортын төрөл						
7	Шатар	Өсвөр үе Насанд хүрэгчид	2024.03.09-10	2024.04.01-05 2024.03-р сард	Шинэ шийдэл клуб	С.Цолмон 99598380
8	Даам	Өсвөр үе Насанд хүрэгчид	2024.02.24-25	2024.03.20-25 2024.04.11-12	Шинэ шийдэл клуб	С.Цолмон 99598380
Дөрөв. Бусад төрөл						
9	Жудо	Өсвөр үе	2024.03.09-10	2024.05.02-05	БТСГ	Т.Энх-Орчлон 89044704
10	Самбо	Өсвөр үе		2024.04.03-05		
11	Чөлөөт	Өсвөр үе	2024.3-р сард	2024.04.19-21	Зааврын дагуу	
12	Таеквондо	Өсвөр үе	2024.03.09-10	2024.04.03-05	БТСГ	О.Буянтогтох 91010766
13	Ширээний теннис	Өсвөр үе Насанд хүрэгчид	2024.03.09-10	202.04.04-07	ЭДЦС "А" заал	Б.Баттүвшин 85505168
14	Хөнгөн атлетик	Өсвөр үе	2024.04.27-28	2024.05.11-12	Налайх	С.Цолмон 99598380
15	Буудлага	Өсвөр үе	2024.03.02	2024.03.24	Цэнгэлдэх хүрээлэн	Т.Энх-Орчлон 89044704
16	Бадминтон	Өсвөр үе	2024.05.11-12	2024.06 сард	Мандал сургууль	Д.Болор-Эрдэнэ
17	Дартс	Насанд хүрэгчид	2024.01.13-14	2024.01.20-21	DOUBLE-Z клуб	Б.Баттүвшин 85505168
18	Адуучин	=	2024.8-р сард	=	=	Т.Энх-Орчлон 89044704
Нийтийн биеийн тамир						
19	Эмэгтэйчүүдийн баярын волейболын тэмцээн		2024.03.07-08	=	БТСГ	Д.Болор-Эрдэнэ 85657474
20	Сар шинийн баярын үндэсний шагайн харвааны тэмцээн		2024.02-р сард	=	БТСГ	О.Буянтогтох 91010766
21	Сар шинийн баярын үндэсний бөхийн барилдаан		2024.02-р сард	=	БТСГ	Т.Энх-Орчлон 89044704
22	Цэргийн баярт зориулсан хууль, хүчний байгууллагуудын тэмцээн		2024.03-р сард	=	БТСГ	Д.Болор-Эрдэнэ 85657474
23	Улс тунхагласны баярт зориулсан хүчит бөхийн барилдаан		2024.11-р сард	=	БТСГ	Т.Энх-Орчлон 89044704

24	Засаг даргын дэргэдэх харъяа агентлагуудын тэмцээн	2024.11-р сард	=	БТСГ	Д.Болор-Эрдэнэ 85657474
25	Иргэдийн спортын наадам	2024.10-р сард	=	БТСГ	С.Цолмон 99598380
26	Ахмадын спортын наадам	2024.5-р сар	=	БТСГ	НБТХ
27	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын наадам	2024.5-р сард	=	БТСГ	НБТХ

- Сум, сургуулиуд тэмцээнд оролцохоосоо өмнө анхан шатны тэмцээн зохион байгуулсан тайлангаа цаасаар өгнө.
- Уг графикийг Биеийн тамир, спортын улсын хорооноос гаргасан 2024 оны улсын аварга шалгаруулах уралдаан тэмцээний графиктай уялдуулан гаргасан болно.

БИЕЙИН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

БАТЛАВ
 БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
 ДАРГА *А.О.О* А ОТГОНБААТАР

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРААС 2024 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ АЙМГИЙН ХВАРГА
 ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН ТЭМЦЭЭНИЙ ГРАФИК

№	СПОРТЫН ТӨРӨЛ	НАСНЫ АНГИЛАЛ	АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН	УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН	БОЛОХ ГАЗАР	ХОЛБОО БАРИХ УТАС
Нэг. Спорт тоглоомын төрлүүд						
1	САГСАН БӨМБӨГ	10-12 нас	2024.09.14-15	2024.10.14-20	БТСГ	О.Буянтогтох 91010766
		13-14 нас		2024.02.19-15		
		15-16 нас	2024.02.23-25	2024.03.25-31		
		17-18 нас		2024.02.26-31		
		Насанд хүрэгчид	2024.03.02-03	=		
2	Волейбол	8-10, 11-12 нас	2024.04.21-22	2024.11 сард	БТСГ	Д.Болор-Эрдэнэ 85657474
		13-14 нас	2024.04.13-14	=		
		15-16 нас	2024.03.23-24	2024.04 сард		
		17-18 нас	2024.02.17-18	2024.03 сард		
		Насанд хүрэгчид	2024.09.21-22	2024.05 сард		
		Ахмад	2024.05.18-19	=		
3	Хөл бөмбөг	10-12 нас	2024.03.30-31		ГИЦС гадаа талбай	Б.Баттүвшин 85505168
		13-14 нас		2024.04.25-05.14		
		15-16 нас	2024.04.13-14	2024.04.25-05.14	ГИЦС гадаа талбай	
		17-18 нас		=		
		Насанд хүрэгчид	2024.01.27-28	2024.05.18-26	БТСГ	
		Хоёр. Үндэсний спортын төрлүүд				
4	Шагайн харваа	Өсвөр үе	2024.05.31	2024.06.22-23	БТСГ	О.Буянтогтох 91010766
		Насанд хүрэгчид	2024.04.27-28	2024.05.16-18		
		Ахмад		2024.05.24-25		
		Сар шигийн харваа	2024.02.17	=		
5	Үндэсний сур	Өсвөр үе	2024.05.11-12	2024.06.22-23	Сурын талбай	С.Цолмон 99598380
		Насанд хүрэгчид		2024.06.24-25		
6	Үндэсний бөх	Өсвөр үе	2024.09.21-22	2024.10.23-25	БТСГ	Т.Энх-Орчлон



БАТЛАВ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.ОТГОНБААТАР
2024 оны 02 сарын 08 өдөр

АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ШАТРЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО.

Аймгийн “ Шатар хөтөлбөр “ -ийн хүрээнд хүүхэд залуус, иргэдийн дунд шатрын спортыг сурталчлан дэлгэрүүлэх, тэдний оюуны спортоор хичээллэхийг дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, авьяас билгийг нээн хөгжүүлэх, өсвөрийн шигшээ багийг бүрдүүлж, системтэй бэлтгэл сургуулилт хийхэд оршино.

ХОЁР. ХУГАЦАА: 2024 оны 02 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд

ГУРАВ. ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР:

- **Өсвөр үеийн тэмцээн:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын их зааланд
- **Насанд хүрэгчдийн тэмцээн:** Аймгийн Засаг даргын тамгын газрын 1 давхрын зааланд тус тус зохион байгуулна.

ДӨРӨВ. БҮРТГЭЛ:

2024 оны 02 дугаар сарын 22-ний 09:00 цагт эхэлж 02 дугаар сарын 23-ны 18:00 цагт хаана. Оролцох тамирчдын мэдүүлгийг ЕБС болон клубын багш нар 02 дугаар сарын 22 -ны өдөр БТСГ-т ирүүлсэн байна.

ТАВ. ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН:

- 2024 оны 02 дугаар сарын 23-ны 18:00 цагт Техникийн зөвлөгөөнөөр ширээний шүүгч, маргаан таслах комиссын гишүүд, тэмцээний журмыг батална.
- Тэмцээнд оролцох сум, сургуулийн баг тамирчид мэдүүлгээ захирлын гарын үсэг тамга тэмдэгтэй, баталгаажуулсан байх.
- Мэдүүлэгийн хамт мандатын 20.000 төгрөгийг бэлнээр авчирч няравт тушааж мандат авна.
- Мандатын мөнгийг шагналд зарцуулах болно.

ЗУРГАА. НАСНЫ АНГИЛАЛ:

1. 6 хүртэлх нас охид, хөвгүүд
2. 7-8 нас охид, хөвгүүд
3. 9-10 нас охид, хөвгүүд
4. 11-12 нас охид, хөвгүүд

5. 13-14 нас охид, хөвгүүд
6. 15-16 охид, хөвгүүд
7. 17-18 нас охид, хөвгүүд
8. Насанд хүрэгчид эрэгтэй, эмэгтэй

ДОЛОО. ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ:

- Тэмцээнийг Швейцарь системээр оролцогчдын тооноос хамаарч 7-9 өрөг тоглуулна. Оролцогчдын тоо 9 ба түүнээс бага бол тойргийн системээр тоглоно.
- Цагийн хяналт талдаа 60 минут байна. Тэмцээнийг FIDE болон МШХ-ны дүрмийн дагуу явуулна. Хүлээлгийн цаг 10 минут байна.
- Тэмцээний Ерөнхий шүүгч, компьютерийн шүүгчээр Монголын шатрын улсын шүүгч ахлан зохион байгуулна.
- **Хайна хагалах:** Хэрэв ижил оноотой гарсан тохиолдолд дараах үзүүлэлтийг харгалзана.
 - ✓ Хоорондын тоглолт
 - ✓ Медум бухколц
 - ✓ Цэвэр хожил
 - ✓ Бергер
 - ✓ Хараас тоглосон өргийн үзүүлэлт
- **Маргаан таслах комиссыг** 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, орлох 2 гишүүний нэрийг батална. Комиссын даргыг Ерөнхий шүүгчтэй зөвшилцсөнөөр томилно.
- Тухайн өрөгтэй холбоотой гомдлыг өрөг дууссанаас хойш 15 минутын дотор бичгээр гаргаж маргаан таслах комиссын даргад өгнө. Гомдлын хариуг маргаан таслах комисс 10 минутын дотор шийдвэрлэнэ.
- Өсвөр үеийн тэмцээний дүнг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын байр эзэлсэн дүнг харгалзан багийн нэгдсэн дүнг гаргаж шалгаруулна.
Багийн дүнг: Алтан медаль 5 оноо
Мөнгөн медаль 3 оноо
Хүрэл медаль 1 оноо тус тус тооцно.

НАЙМ. ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- Биеийн тамир, спортын газар

ЕС. ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

- Дундговь аймгийн "Ураг өрөг" шатрын холбоо
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар
- Шатрын клубүүд

АРАВ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

Насны ангилал болон төрөл тус бүрээр 3 байр, багийн дүнгээр 3 байр нийт 51 байрыг тус тус шалгаруулна.

- Тэргүүн байр өргөмжлөл, алтан медаль, мөнгөн шагнал
- Дэд байр өргөмжлөл, мөнгөн медаль, мөнгөн шагнал

- Гутгаар байр өргөмжлөл, хүрэл медаль, мөнгөн шагнал
- Өсвөрийн нас, насны ангилалд түрүүлсэн эрэгтэй, эмэгтэй хүүхэд Улсын аваргад оролцох эрх авна.

Багийн шагнал

- ✓ Тэргүүн байр Цом, өргөмжлөл, мөнгөн шагнал
- ✓ Дэд байр өргөмжлөл, мөнгөн шагнал
- ✓ Гутгаар байр өргөмжлөл, мөнгөн шагнал

АРВАН НЭГ. ТЭМЦЭЭНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ:

02 сарын 24 Бямба гариг	1-р өрөг	09:00-11:00
	Нээлтийн ажиллагаа	11:00-11:30
	2-р өрөг	11:30-13:30
	Цайны завсарлага	13:30-15:00
	3-р өрөг	15:00-17:00
	4-р өрөг	17:00-19:00
02 сарын 25 Ням гариг	5-р өрөг	09:00-11:00
	6-р өрөг	11:00-13:00
	Цайны завсарлага	13:00-14:00
	7-р өрөг	14:00-16:00
	8-р өрөг	16:00-18:00
	9-р өрөг	18:00-20:00
	Хаалтын ажиллагаа	20:00-20:30

ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГДИЙН ХУРАЛ



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

- НАСАНД ХҮРЭГЧИД,
- ӨСВӨР ҮЕИЙН

Шатрын АЙМГИЙН АВАРГА

ШАЛГАРЧУЛАХ ТЭМЦЭЭН

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
АЙМГИЙН ШАТРЫН ХОЛБОО, КЛУБУУД



2024.02.24–25

Мандалговь хот



БАТЛАВ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *А.Отгонбаатар* А.ОТГОНБААТАР
2024 оны 02 сарын 01 өдөр

ЗЮА0035 9033653

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ДУНДГОВЬ АЙМГИЙН ВОЛЕЙБОЛЫН
ИДЭРЧҮҮДИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2024 оны 02 дугаар сарын 01

Сайнцагаан сум

Нэг: Тэмцээний зорилго:

Өсвөрийн волейболчдын ур чадварыг дээшлүүлж тамирчдын залуу халааг бэлдэх, шилдэг тамирчдыг төрүүлэн гаргах, идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд, оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулахад тэмцээний зорилго оршино.

Хоёр: Хамрах хүрээ

- 2.1 Тэмцээнд ЕБСургууль болон Политехникийн коллеж орон нутгийн спорт клубүүд оролцож болно.
- 2.2 Насны ангилал /2006.01.01-ний өдрөөс хойш төрсөн/
- 2.3 Нэг багт 9 тамирчин 1 дасгалжуулагчийн бүрэлдэхүүнтэй байна.

Гурав: Тэмцээн зохион явуулах журам хугацаа, техникийн зөвлөгөөн

- 3.1 2024 оны 02 дугаар сарын 17,18-ний өдрүүдэд БТСГ -ын зааланд зохион байгуулна.
- 3.2 Тамирчдын бүрдүүлж ирэх бичиг баримт
 - ❖ Иргэний үнэмлэх
 - ❖ Гадаад паспорт
 - ❖ Сурагчийн хувийн хэрэг
 - ❖ Тамирчин тус бүр 1% цээж зураг авч ирэхийг анхаарна уу
- 3.3 Тэмцээнд оролцох сургууль, клуб, сумдаас эрэгтэй, эмэгтэй тус бүр 2 баг оролцож болно.
- 3.4 Тэмцээнд оролцох багийн мэдүүлэгт овог нэр, нас, биеийн өндөр, регистрийн дугаар, хувийн дугаар, тоглогчийн үүрэг, эрүүл мэндийн байдал зэргийг заавал бичсэн байх бөгөөд мэдүүлгийг /компьютерт/ шивсэн албан ёсны тамга тэмдэгтэй баталгаажсан байна.
- 3.5 Тэмцээнийг МВХ-ны дүрмийн дагуу шүүн явуулна.
- 3.6 2024 оны 02 дугаар сарын 16 -ний өдөр 14 цагт мандат олгоно.
- 3.7 17 цагт техникийн зөвлөгөөн БТСГазар болно
- 3.8 Тамирчдын мандатын хураамж 3000 төгрөг
- 3.9 Тэмцээний эрхийн төлбөр 60,000

Дөрөв: Шагнал урамшуулал

- 1 дүгээр байр:** Алтан медаль, өргөмжлөл
- 2 дугаар байр:** Мөнгөн медаль, өргөмжлөл
- 3 дугаар байр:** Хүрэл медаль, өргөмжлөл

Эрэгтэй, эмэгтэй тус бүр шилдэг холбогч, шилдэг довтолгоч, шилдэг тэгш, тоглогчийг шалгаруулна.

Багийн дүн:

- 1 дүгээр байр:** Цом, Өргөмжлөл
- 2 дугаар байр:** Өргөмжлөл
- 3 дугаар байр:** Өргөмжлөл

Харилцах утас: 89862538 85657474



ДУНДГОВЬ АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ИДЭРЧҮҮДИЙН ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭН

2024.02.17-18



БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ЗААЛАНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАНА.



ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ШАГАЙН САЛБАР
ХОЛБОО:
Ш.ОТГОНБАР



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ШАГАЙН САЛБАР
ХОЛБОО:

Ц.ОТГОНБАЯР



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
“ГОВЬ ГУРВАН
САЙХАНЫ
МЭРГЭЧҮҮД” ИЯГАЙН
САЛБАР ХОЛБОО:

Ч.БУИНАА



**ХVII ЖАРНЫ МОДОН ЛУУ ЖИЛИЙН САР ШИНИЙН БАЯРТ ЗОРИУЛСАН ДУНДГОВЬ,
ӨМНӨГОВЬ, ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН НЭРЭМЖИТ “ГОВИЙН
БҮСИЙН САР ШИНИЙН ХАРВАА-2024” ҮНДЭСНИЙ ШАГАЙ ХАРВААНЫ
ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2024 оны 02-р сарын 05-ны өдөр

Өмнөговь аймаг

Нэг: Зорилго

“ЮНЕСКО”-ийн Хүн төрөлхтөний Соёлын биет бус өвд бүртгэгдсэн Монголын Үндэсний уламжлалт спорт тоглоом шагайн харвааг өргөн дэлгэр хөгжүүлэх, шагайн харвааны алдар цуутай өв тээгчид, ахмад мэргэн харваачдыг алдаршуулах, олон нийтийн мэдээллийн сувгуудыг ашиглан сурталчлах, шагайн харвааны уламжлалт ёс жаягтйг залуу хойч үедээ өвлүүлэх, харваачдын ур чадварыг дээшлүүлэх, нутаг нутгийн харваачид оноо нэцээ уралдуулж, харилцан туршлага солилцоход оршино.

Хоёр: Тэмцээн зохион байгуулах байршил, хугацаа

2.1. Тэмцээн Дундговь, Өмнөговь, Дорноговь аймгуудад цувралаар зохион байгуулагдана. Дундговь аймгийн Мандалговь сумын Биений тамир, спортын газарт 2024 оны 02 сарын 17-ны өдөр, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 7-р сургуулийн спорт заланд 2024 оны 02 сарын 18-ны өдөр, Дорноговь аймгийн Сайншанд сумын Шагайн өргөөнд 2024 оны 02 сарын 24-ний өдөр тус тус зохион байгуулагдана.

2.2. Тэмцээний сугалаа Дундговь аймагт 2024 оны 02 сарын 17-ны өдөр, Өмнөговь аймагт 2024 оны 02 сарын 18-ны өдөр, Дорноговь аймагт 2024 оны 02 сарын 24-ний өдөр тус тус явагдана.

2.3. Тэмцээний нээлтийн ёслолын үйл ажиллагаа тэмцээн эхлэх өдрийн 12:00 цагаас болно.

Гурав: Тэмцээнийг зохион байгуулах ерөнхий заавар

3.1. Тэмцээнийг Монголын шагайн харвааны холбооны 2018 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн V Их хурлаар шинэчлэн баталсан “ Шагайн харвааны нэгдсэн дүрэм”-ийн дагуу явуулна.

3.2. Өмнөговь, Дундговь, Дорноговь аймагт явагдах тэмцээний мэдүүлгийг тэмцээн эхлэх тухайн өдрийн 8:00 цагаар тасалбар болгож, ирсэн багуудын мэдүүлгээр нэгтгэн гаргана.

3.3. Тэмцээнд орох багуудын хураамж тус бүр 100 000 төгрөг бөгөөд хураамжийг дараах дансанд шилжүүлнэ.

-Өмнөговь аймаг: “Говь Гурван Сайханы мэргэчүүд” шагайн салбар холбооны ХААН банк дахь 5608279599 тоот данс,

-Дундговь аймаг: Шагайн салбар холбооны тэргүүн Ц.Отгонбаярын ХААН банк дахь 5466223737 тоот данс,

-Дорноговь аймаг: Шагайн салбар холбоо, Э.Гомбосүрэнгийн ХААН банк дахь 5305154835 тоот дансанд тус тус шилжүүлснээр багийн бүртгэл баталгаажна.

3.4. Тэмцээн Үндэсний шагай харвааны насанд хүрэгчдийн “Багийн Харваа”-ны төрлөөр зохион байгуулагдана. / Жич: Өсвөрийн болон ахмадын хурууны баг харваачид насанд хүрэгчдийн төрөлд хамт тоглож болно./

3.5. Тэмцээнд оролцож буй харваач бүр МШХХ-оос “Дээлтэй Шагайн харваа”-ны уриалга гаргасантай холбогдуулан Үндэсний дээл, хувцастай байна. Үндэсний дээл хувцасгүй болон багийн гишүүдээс согтууруулах ундаа хэрэглэсэн байвал тухайн багийг тэмцээнд оролцуулахгүй.

3.6. МШХХ-оос баталсан цолны загвар энгэрийн тэмдэг, малгай тэмдгийг хэрэглэж хэвшихэд бүх цолтой харваачид анхаарна.

Дөрөв: Шагнал, урамшуулал

4.1. Багийн харваа / Зохион байгуулах аймаг тус бүр /

I байр – Алтан медаль, өргөмжлөл, 8,000,000 төгрөг

II байр – Мөнгөн медаль, өргөмжлөл 6,000,000 төгрөг

III байр – Хүрэл медаль, өргөмжлөл, 4,000,000 төгрөг

IV байр – Өргөмжлөл, 2,000,000 төгрөг

Тав:

5.1. Тэмцээний зохион байгуулалттай холбоотой мэдээллийг дараах утсаар лавлана.

Дундговь аймаг: 91010766

Өмнөговь аймаг: 99016066, 99534753

Дорноговь аймаг: 99022615



XVII жарны “ХИЛЭНТ ЭХ” хэмээх модон ЛУУ жилийн сар шинийн баярт зориулсан Дундговь, Өмнөговь Дорноговь аймгуудын Засаг даргын нэрэмжит

ГОВИЙН БҮСИЙН
САР ШИНИЙН **2024**
Шагайн харваа

Зохин байгуулагч:

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын газар
Дундговь аймгийн Шагайн салбар холбоо



БАТЛАВ:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *А.Оюу* ОТГОНБААТАР

2024 оны 01 сарын 05 өдөр



ДУНДГОВЬ ДАРТСЫН ХӨЛБӨӨНЫ
ТЭРГҮҮН *Б.Батцож* Б.БАТЦООЖ

ДУНДГОВЬ АЙМГИЙН АВАРГА

ШАЛГАРУУЛАХ ДАРТСЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Дартсын спортыг орон нутагтаа сурталчилан таниулах, түгээн дэлгэрүүлэх, дартсын спортыг бүх нийтийн спорт болгох, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх. Мөн клубийн үйл ажиллагааг идэвхижүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Дундговь аймагт байнга оршин суух Монгол улсын иргэн, өөр орон нутагт оршин суух Дундговь аймгийн регистрийн дугаартай уугуул иргэд оролцох боломжтой. (Уугуул: Дундговь аймагт төрсөн Дундговь аймгийн РД-тай хүмүүс, Суугуул 2024. 01.01-ний өдрөөс өмнө Дундговь аймгийн харъяалалд шилжин ирсэн бүх хүмүүсд нээлттэй)

Гурав. Тэмцээний төрөл, хураамж, бүртгэл

Тэмцээний төрөл:

- Эрэгтэй ганцаарчилсан
- Эмэгтэй ганцаарчилсан
- Багийн төрөл (2 эрэгтэй, 1 эмэгтэй)

Тэмцээний хураамж:

- Ганцаарчилсан төрөл – 20.000 ₮
- Багийн төрөл – 60.000 ₮

Хураамж шилжүүлэх данс:

Данс эзэмшигч: Ө. Цэрэнмаа

Банкны нэр: Хаан банк

Дансны дугаар: 5306278952

Гүйлгээний утга: Овог, нэр, хүйс, утасны дугаар

Тэмцээний бүртгэл: tserenmaa9899@gmail.com (Утас: 88744845, 99919160) хаяг руу зурвас илгээж бүртгүүлнэ.

- Бүртгэл хаах хугацаа 2024 оны 01 сарын 11 – ний 20:00 цагт хаагдана.
- Хураамжаа шилжүүлсэн тохиолдолд бүртгэл баталгаажих болно.

Дөрөв. Тэмцээн зохион байгуулах өдөр, байршил

Хаана: Дундговь аймгийн DOUBLE-Z² клубийн байранд. (Оролцох хүний тооноос хамаараад зааланд болох боломжтой)

Хэзээ: 2024 оны 01 сарын 13-нд 09:00 цагаас эхэлнэ.

Тав. Шагнал

Ганцаарчилсан болон багийн төрөл:

- 1-р байр Цом, Алтан медаль, Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 2-р байр Мөнгөн медаль, Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 3-р байр Хүрэл медаль, Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 3-р байр Хүрэл медаль, Өргөмжлөл, мөнгөн шагнал

Зургаа. Тэмцээний журам

Тэмцээний оноолт сугалааг 2024 оны 01 сарын 12-ны өдрийн 20 цагт Live- аар хийнэ. Тамирчид болон багууд 4-8 хэсэгт хуваагдаж сугалаагаар хуваагдаж хэсэгтээ тойргоор тоглоно. Хэсгийн хожлын оноогоор эхний 2 тамирчин / баг / шалгарч цаашдаа хасагдах системээр аваргын төлөө өрсөлдөх болно.

Ганцаарчилсан болон багийн төрлийн хэсгийн тоглолт, хасагдах шатны тоглолт мөн хагас шигшээ тоглолтууд түрүүлж 3 хожлоор, финалын тоглолт 4 хожлоор явагдана.

1. Тоглолт төрөл хамаарахгүйгээр 501 онооноос эхэлнэ.
2. Тоглолтыг хоёрын үржвэрээр тэглэж дуусгана.
3. Тамирчид 45 суманд багтаан тоглолтоо дуусгаагүй тохиолдолд дүрмийн дагуу буханд 1 сум шидэж хамгийн ойр шидсэнээр хожлыг шийдвэрлэнэ.
4. Өрсөлдөгч нар шодож хэн түрүүлж буханд шидэхээ шийдвэрлэх бөгөөд самбарын төвд хэн ойр сумаа шидсэн нь тоглолтыг эхлүүлнэ.
5. Хэрэв өрсөлдөгч нарын хожлын харьцаа тэнцвэл сүүлчийн шийдвэрлэх тоглолтыг тоглолтын дарааллын дагуу явуулна.
6. Тамирчид шүүгч болон өрсөлдөгчдөө оноогоо гүйцэт харуулсны дараа сумаа самбараас авна. Хэрэв гүйцэт харуулалгүйгээр сумаа авсан тохиолдолд авсан 3 сумны нийлбэр оноог тооцохгүй.
7. Самбараас сум авах үед унасан сумны тоог оноонд тооцох бөгөөд самбарт гар хүрэхээс өмнө унасан сумны оноог оноонд тооцохгүй.
8. Хэрэв сум ар араасаа давхралдаж зоогдсон тохиолдолд зөвхөн эхний сумны оноогоор тооцно.
9. Хэрэв 2 сумны хооронд сум орж тогтоод сумны үзүүр самбартаа хүрсэн бол үзүүр хүрсэн оноог тооцно.
10. Шидэлт гүйцэтгэсэн тамирчид самбараас сумаа авч баруун талаар нь тойрон өрсөлдөгчдөө саад болохооргүй зайтай зогсох ёстой.
11. Хэсгийн тоглолтын оноог чанараар буюу (+,-) онооны зөрүүгээр тооцно.

12. Тамирчдыг зарлаад 10 минутын дотор ирээгүй тухайн тоглолтыг "0" оноогоор буюу хожигдсонд тооцно. Хоёр тамирчин хоёулаа ирээгүй тохиолдолд "0" оноогоор буюу хожигдсонд тооцно.

Долоо. Хувцаслалт

1. Тамирчин бүр өөрийн болон багийн онцлогийг илтгэсэн хувцастай байх
2. Малгай, урт түрийтэй болон өндөр өсгийтэй гутал зэргийг тоглолтонд өмсөхийг хориглоно.
3. Тэмцээнд оролцогчид олон улсын тэмцээний журмын дагуу хар өмд, хар өнгийн гутал өмссөн байх.

Анхаарах зүйлс:

1. Тоглогчид өөрсдийн сумтай ирнэ.
2. Тоглолттой холбоотой гарсан маргааныг шүүгч шийдвэрлэнэ.
3. Хөдөө орон нутгаас ирж буй тамирчид өөрсдийн аюулгүй байдлаа сайтар хангаж замд гарах

Тэмцээнийг зохион байгуулах комисс


- БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР
- ДУНДГОВЬ ДАРТСЫН ХОЛБОО
- DOUBLE-Z² КЛУБ

2024.01.04



ДУУДГОВЬ АЙМГИЙН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ

ДАРТСЫН ТЭМЦЭЭН

 DOUBLE-Z КЛУБЫН БАЙР

 2024.01.13-14

 88744845, 99919160



Тэмцээний жин тус бүрийн 1,2,3,-р байрт шалгарсан тамирчдыг Алт, Мөнгө, Хүрэл медаль өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

Зургаа: БАГШ ДАСГАЛЖУУЛАГЧ НАРЫН АНХААРАЛД

- ❖ Багш дасгалжуулагчид зөвхөн ёслолын хувцастай байх.
- ❖ Тамирчин мандат 3000 төгрөг иргэний үнэмлэх,гадаад паспорт, 3x4 Хэмжээтэй 1% цээж зурагтай ирэх
- ❖ Тамирчид цагаан цэнхэр өнгийн жүдогитой барилдах.
- ❖ Цэнхэр өнгийн жүдогигүй тохиолдолд үндсэн бүсэн дээрээ улаан бүс бүсэлж барилдана.
- ❖ Багийн дүн гаргахдаа медалийн чанараар, багийн нийлбэр дүнгээр 1,2,3-р байр эзлүүлж шагнаж урамшуулна.
- ❖ Нээлт шагнал гардуулах ёслолын ажиллагаанд зөвхөн цагаан өнгийн жүдогитой оролцох.

Долоо: Шүүлт зохион байгуулалт

Монголын жүдо бөхийн холбооны шүүгчдийн зөвлөлөөс томилогдсон шүүгчид шүүн явуулна.

ТЭМЦЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

2024-03-23 нд

14:00-16:00 цагт Бүртгэл мандат олголт,Мандатын хураамж 3000 төгрөг

16:00-17:00 цагт Техникийн зөвлөгөөн

17:00-17:30 цагт Албан ёсны жин үзнэ / **Бага, дунд нас** /

18:00 цагт Сугалаа гараар татна.

2024-03-24 нд

09:00 – 13:00 цаг Урьдчилсан шатны барилдаан

13:00 – 14:00 цаг Нээлтийн ёслолын ажиллагаа

14:00 17:00 цаг Шигшээ барилдаан,Шагнал гардуулах ёслолын ажиллагаа

17:00-17:30 цаг Албан ёсны жин үзнэ / **Ахлах нас** /

18:00 цагт Сугалаа гараар татна.

2024-03-25 нд

09:00 – 13:00 цаг Урьдчилсан шатны барилдаан

13:00-14:00 цаг цайны цаг

14:00 17:00 цаг Шигшээ барилдаан,Шагнал гардуулах ёслолын ажиллагаа

Утас:97020219,95117755

ЖУДО БӨХИЙН 2024 ОНЫ ӨСВӨР ҮЕИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН АВАРГА
 ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫНСУРГУУЛИАС
 ОРОЛЦОХ ЭРЭГТЭЙ БАГ ТАМИРЧДЫН МЭДҮҮЛЭГ

БАТЛАВ

Тамга	Овог нэр албан тушаал СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ.....	Байгууллагын нэр ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
-------	--	--

Бага нас 2012 он

№	Жин	Цээж зураг	Овог нэр	Регистр	Хүйс	Биеийн байдал
1.						
2.						
3.						

Дунд нас 2010,2011 он

№	Жин	Цээж зураг	Овог нэр	Регистр	Хүйс	Биеийн байдал
1.						
2.						
3.						

Ахлах нас 2007,2008,2009

№	Жин	Цээж зураг	Овог нэр	Регистр	Хүйс	Биеийн байдал
1.						
2.						
3.						

БАГИЙН ДАСГАЛЖУУЛАГЧ
 БАГИЙН ЭМЧ

/ Утасны дугаар /
 / Утасны дугаар /

БАТЛАВ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



2024 оны 03 дугаар сарын 11

МОНГОЛ УЛСАД БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАР ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ
ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ДУНДГОВЬ АЙМГИЙН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ЖҮДО БӨХИЙН 2024 ОНЫ ӨСВӨР ҮЕИЙН ТЭМЦЭЭНИЙ
УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Монгол улсад Биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, жүдо бөхийн спортыг сурталчлах, өсвөр үеийн тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, өндөр зэрэгтэй тамирчдыг бэлтгэн гаргахад гол зорилго оршино.

Хоёр. Зохион байгуулах газар хугацаа

Тэмцээн 2024 оны 03 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд Биеийн тамир, спортын газарт болно.

Гурав. Оролцогчдын нас, жингийн ангилал

Бага нас: 2012 оноос хойш төрсөн охид хөвгүүд / Өчих, боох мэх хориглоно /

Хөвгүүд : 27кг, 30кг, 34кг, 38кг, 42кг, 46кг, -50кг, +50кг

Охид: 28кг, 32кг, 36кг, 40кг, 44кг, -48кг +48кг

Дунд нас: 2010-2011 онд төрсөн охид хөвгүүд / хөвгүүд 34кг, 38кг, охид 36кг өчих, боох мэх хориглоно /

Хөвгүүд : 34кг, 38кг, 42кг, 46кг, 50кг, 55кг, -60кг, +60кг

Охид: 36кг, 40кг, 44кг, 48кг, 52кг -57кг +57кг

Ахлах нас: 2007-2009 онд төрсөн охид хөвгүүд

Хөвгүүд : 50кг, 55кг, 60кг, 66кг, 73кг, -81кг, +81кг

Охид: 40кг, 44кг, 48кг, 52кг, 75кг, -63кг +63кг

Дөрөв: Бүртгэл, мандат олголт

2024 оны 03 дугаар сарын 23 - нд 14:00-16:00 цагийн хооронд Биеийн тамир, спортын газарт болно.

Тав. Шагнал урамшуулал